



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

**МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ БОЛОН САНХҮҮЖИХ ЧАДАВХЫН
ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН,
ХОРООНЫ БОДЛОГЫН ЧИГЛЭЛ**

**ҮЦГ-ын ХХЗШБҮХ-ийн дарга
Б.Долгорсүрэн**

2014.12.18

ЗЭЭЛЖИХ БОЛОН САНХҮҮЖИХ ЧАДАВХЫН ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ:

- **ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**
- **ТУЛГАМДСАН АСУУДАЛ**
- **ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА**
- **АЧ ХОЛБОГДОЛ**
- **ХОРООНООС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО**

Монгол Улсын дахь зээлжих болон санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйлчилгээний талаар тусгасан хууль:

2011 он

Зээлийн мэдээллийн тухай хууль

14.1.3 дахь заалтад “Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтооно”

2013 онд

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/

50 дугаар зүйлд “Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа”

ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН



Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 50 дугаар зүйл:

Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа:

50.1. Үнэт цаас гаргагчийн санхүүжих чадавхын зэрэглэлийг тусгайлан боловсруулсан аргачлалд үндэслэн тогтоох хөндлөнгийн, хараат бус ажиллагааг санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа гэнэ.

50.2. Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд зохих нөхцөл, шаардлагыг хангасан бол үнэт цаасны зах зээл дэх тодорхой төрлийн санхүүгийн хэрэгсэлд дүн шинжилгээ хийж, тэдгээрийн чанар, эрсдэл, өгөөж зэрэг үзүүлэлтээр зэрэглэл тогтоож болно.

50.3. Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь сонирхлын зөрчил бүхий харилцагчид үйлчилгээ үзүүлэх, хуурамч зэрэглэл тогтоох, дутуу мэдээлэл болон шинжилгээнд үндэслэн зэрэглэл тогтоохыг хориглоно.

50.4. Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох аргачлал, үйл ажиллагааны журмыг Хороо тогтооно.

ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН



Хороо хуулиудын хэрэгжилтийг хангуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд:

2010 оны 97 дугаар тогтоол

“Зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх журам”

Зорилго: Хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үнэт цаас, зээлжих чадвар, бонд болон түүнтэй адилтгах өрийн бичигт дүн шинжилгээ хийж, эрсдлээр нь ангилан зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох, бүртгэх болон түүнтэй холбогдсон харилцааг зохицуулна.

2010 оны 5 дугаар сар:

Монголрейтинг сервис ХХК-д зэрэглэл тогтоох үйлчилгээ эрхлэх 3 жилийн хугацаатай эрх олгосон.

2011 оны 10 дугаар сард: Монголрейтинг сервис ХХК-ийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалт хийж, шалгалтын тайлангаар үүрэг даалгавар өгсөн.

Хороо хуулиудын хэрэгжилтийг хангуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд:



2011 оны 12 дугаар сард:

“Компанийн зээлжих зэрэглэл тогтоох үйлчилгээний талаар Хорооноос баримтлах бодлого”

2013 оны 529 дүгээр тогтоол

“Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагааны зохицуулалтын журам”

Зорилго: Үнэт цаас гаргагчийн санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл болон зэрэглэл тогтоох байгууллагын үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

2014 оны 6 дугаар сард:

Монголрейтинг сервис ХХК-ийн зэрэглэл тогтоох үйлчилгээ эрхлэх эрхийг хүчингүй болгосон.

ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН



“Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллааны зохицуулалтын журам”:

ЗТБ-ын хувьцаа эзэмшигч нь дараах хуулийн этгээдүүд байна:

- Компанийн тухай хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй санхүүгийн байгууллага болон олон улсын санхүүгийн байгууллага;
- Монголбанкны тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй банк;
- Сүүлийн таван жилд жилийн аудитлагдсан тайлангаар үйл ажиллагааны борлуулалтын орлого нь нэг тэрбум төгрөгөөс доошгүй, Монгол улсад бүртгэлтэй компани;
- Зэрэглэл тогтоох үйл ажиллагаа гурваас доошгүй жил эрхэлж буй гадаад улсын зэрэглэл тогтоох байгууллага.

ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



Зээлийн Мэдээллийн Төв ХХК:

2009 онд: Монголын банкны холбооны санаачлагаар, арилжааны банкууд хамтран хөрөнгө оруулж байгуулсан.

Монголрейтинг сервис ХХК:

2010 онд: Хороо компанийн зэрэглэл тогтоох үйлчилгээ эрхлэх 3 жилийн хугацаатай эрх олгосон.

2011 онд: Монгол даатгал ХХК анх удаа дотоодын зэрэглэл тогтоох байгууллагаар зэрэглэлээ тогтоолгосон.

2014 онд: Компанийн зэрэглэл тогтоох үйлчилгээ эрхлэх эрхийг хүчингүй болгосон.

Эрдэмтэн судлаачид:

Арилжааны банк болон бусад санхүүгийн байгууллагуудыг зэрэглэлийг өөрсдийн сонгосон аргачлалаар тогтоож, харьцуулсан судалгааг хийж байна.

Санхүүгийн зах зээлд зэрэглэл тогтоох үйлчилгээ бүрэн нэвтэрч чадахгүй байгаа шалтгаан:

Субъектив

- Эрэлт бий болоогүй.
- Ойлголт төлөвшөөгүй.
- Зэрэглэлд итгэх итгэл бий болоогүй.

Объектив

- Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах боломж хязгаарлагдмал.
- Зэрэглэл тогтоох үйлчилгээг бий болгох, зах зээлд нэвтрүүлэх, хөгжүүлэхэд чиглэгдсэн бодлогын асуудал буюу хөшүүргийн механизм орхигдсон.
- Зохицуулагч болон оролцогчдын эрх, үүрэг, хариуцлагын тусгасан бие даасан эрх зүйн зохицуулалт байхгүй.

ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА



Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль /2010 он/
- Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль /2010 он/
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга, 2010 он/
- Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль /2010 он/

Уламжлалт санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ:

- Банк, ББСБ-ын зээлдэгчид.
- Даатгалын үйлчилгээ.
- Үнэт цаас, бонд.
- Өрийн бичиг.
- Олон нийтэд анх удаа хувьцаагаа санал болгох.
- Үүсмэл санхүүгийн хэрэгсэл.

ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЧ ХОЛБОГДОЛ



Зохицуулагч байгууллагад:

- Төр өөрийн хүлээх зарим үүрэг зэрэглэл тогтоогч байгууллагын хөндлөнгийн дүгнэлтээр хангагдах.
- Санхүүгийн зах зээлийн шалгуур үзүүлэлттэй болох.

Санхүүгийн зах зээлд:

- Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ хөрөнгийн зах зээлд нэвтрэх гол түлхүүр.
- Өрсөлдөөнийг нэмэгдүүлэх.
- Мэдээллийн ил тод байдал.
- Санхүүжилтийн эх үүсвэрийн олон төрөл бий болох.

Санхүүгийн зах зээлд оролцогчдод:

- Эрсдэл болон дампуурлаас урьдчилан сэргийлэх.
- Санхүүгийн зах зээлд дүн шинжилгээ хийх гол тулгуур.
- Нэр хүндийн баталгаа.
- Бусадтай харьцуулах боломж.
- Эрсдэлээ хэмжиж, удирдахад энгийн, хялбар.
- Хөрөнгө оруулалтандаа хяналт тавих нөхцөл бүрдэнэ.

Зэрэглэл тогтоох үйлчилгээний эрх зүйн зохицуулалтын орчинг оновчтой тодорхойлж, боловсронгуй болгох:

- Зэрэглэл тогтоох үйлчилгээний тухай хуулийн төсөл боловсруулах.
- Хорооны баталсан журамд өөрчлөлт оруулах.

Хорооноос бодлогын хүрээнд тодорхойлсон боломжит хувилбарыг сонгох:

Хувилбар А:

Зэрэглэл тогтоох үйлчилгээнд сайн дураар хамрагдах буюу компанийн зэрэглэлийг сайн дурын үндсэн дээр тогтоолгох.

Хувилбар Б:

Зэрэглэл зайлшгүй тогтоолгохыг Хорооны зохицуулалтын журмаар дамжуулан шаардах.

Хувилбар В:

Зөвхөн хөрөнгө оруулагчдын шаардлага, хүсэлтээр тухайн үнэт цаас гаргагч нь компанийн зэрэглэлийг тогтоолгодог байх.

**ТУС УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ЗӨВЛӨМЖ ГАРГАЖ САНХҮҮГИЙН
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЭВЛӨЛД ХҮРГЭХ.**



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

Санхүүгийн зохицуулах хороо
ҮЦГ-ын ХХЗШБҮХ-ийн дарга
Б.Долгорсүрэн

2014.12.18